

УДК 930.85

ӨВӨР МОНГОЛЫН ЯРУУ НАЙРАГЧ Д. ЦЭРЭНВАНЖИЛЫН ШҮЛГИЙН УРАН САЙХАН

С. Цоморлиг

МУИС-ийн Улаанбаатар сургуулийн докторант,
Хөх хот, Өвөр Монголын өөртөө засах орон, БНХАУ
E-mail: 2676423124@qq.com

Хураангуй

1961 оны 9 сарын 7-нд Өвөр Монголын өөртөө засах орны Шилийнгол аймгийн Баруун үзэмчин хошууны Жаран сумын Жаран гацааны нутагт Долоод овогт Донров, Шарнууд овогт Отгон нарын тав дахь хүүхэд болон мэндэлсэн. Зохиол бүтээл туурвих болсон цагаасаа өнөөг хүртэлх гуч гаруй жилийн турш Өвөр Монголын утга зохиолын ертөнцөд түүний зохиол бүтээлийг уншигч түмэн шимтэн уншдаг. Түүний шүлгүүдээс монголчуудын цайлган сэтгэл, нүүдэлчин ардын аж амьдрал, эх байгальтайгаа шүтэлцэн оршин байдгийн дүрслэлийг “Бид Монголоороо байх л учиртай, Монгол сэтгэлгээг бид гадаадаас олохгүй” гэж ярих дуртай түүний «Гаднаа морьтой монгол айл» шүлгээс харж болно. Монгол ахуйг дүрсэлсэн олон шүлэг нь хэл, соёлын гайхамшигийг тусгасан байдаг. Өнөөгийн Өвөр Монголын яруу найрагт монгол хэлний яруу тансаг хуучны үг хэллэгийн хэрэглээ багасаж, сэтгэлгээ ядуурч, сэдвийн хүрээ цөөрч явцуурч байгаа ийм цаг үед Д. Цэрэнванжилын шүлгүүд баян тансаг үгийн сан, монгол ахуйг үгээр зураглах нь уран бүтээлчийн өнгө төрх юм. XX зууны 80 хэдэн оноос уран бүтээлээ туурвиж эхэлсэн Д. Цэрэнванжил нь эдүгээ БНХАУ-ын цөөн тоот үндэстний зохиолчдын нийгэмлэгийн гишүүн, Өвөр Монголын зохиолчдын нийгэмлэгийн гишүүн, Шилийнгол аймгийн зохиолчдын нийгэмлэгийн дэд тэргүүлэгч зэрэг албан тушаалыг хажиж буй уран бүтээлч билээ. Д. Цэрэнванжилын уран бүтээл хэл найруулга, туурвилзүйн онцлогоороо бусад уран бүтээлчдээс ялгарах тул яах аргагүй өгүүлэн буй үеийг төлөөлөхуйц уран бүтээлчийн нэг болж байна. Д. Цэрэнванжилын уран бүтээлд үндэс угсаагаа хайрлах, монгол үндэстнийхээ хувь заяаны төлөө санаа зовох, монгол үндэстний бадран хөгжих болтугай гэх хүсэл найдлага, итгэл үнэмшлээ илэрхийлсэн монгол соёл уламжлалын зүйлс нь энэ уран бүтээлчийн үнэт зүйлс болох тухай энэ өгүүлэлд бичжээ.

Түлхүүр үг

Цэрэнванжил, яруу найраг, монгол соёл, нүүдэлчний оюун санаа.

UDC 930.85

THE ARTISTRY OF THE POEMS BY INNER MONGOLIAN POET D. TSERENVANJIL

S. Tsomorlig

Doctoral student at Ulaanbaatar University, Ulaanbaatar, Mongolia a poetess, Hohhot, Inner Mongolia Autonomous Region, People's Republic of China

E-mail: 2676423124@qq.com

Annotation

On September 7, 1961, he was born as the fifth child of Donrov with the family name Dolood and Otgon with the family name Sharnud in the area of Jaran village of Jaran soum, Western Uzemchin County, Shiliinggol Province, the Inner Mongolia Autonomous Region. For more than thirty years from the time he started writing until now, his works have been read enthusiastically in the literary world of Inner Mongolia. In his poems, you can see the description of Mongols' innocence, the lifestyle of nomadic people, and the existence in worship with mother nature in the poem "Mongolian family with horses outside" by him who likes to say "We have to be Mongolian, we can't find Mongolian mentality from abroad". Many of his poems that describe Mongolian life reflect the wonders of language and culture. In today's poetry of Inner Mongolia, the use of the exquisite and elegant words of the Mongolian language is being reduced, the thinking is being impoverished, and the scope of the subject is being narrowed, but D. Tserenvanjil's poems depict a rich vocabulary and Mongolian life with words, which clearly shows the color of this artist. D. Tserenvanjil, who started writing his poems in the 80s of the 20th century, is now an artist who is a member of the Writers' Association of Chinese Minority Ethnicities, a member of the Inner Mongolian Writers' Association, and the deputy head of the Writers' Association of Shiliinggol Province. D. Tserenvanjil's works are distinguished from other artists by their language composition and creativity, so he is definitely one of the artists who can represent the current period. It is written in this paper that D. Tserenvanjil's works are written about the values of the Mongolian culture and traditions, which express the hope and belief that the Mongolian nation will grow and develop, as well as the concern for the fate of the Mongolian nation.

Key words

Tserenvanjil, poetry, Mongolian culture, nomadic spirit.

УДИРТГАЛ

1. Д. Цэрэнванжил нь Өвөр Монголын яруу найргийн нэрт төлөөлөгч болох нь

1961 оны 9 сарын 7-нд Өвөр Монголын өөртөө засах орны Шилийнгол¹ аймгийн Баруун үзэмчин хошууны Жаран сумын Жаран гацааны нутагт Долоод овогт Донров, Шарнууд овогт Отгон нарын тав дахь хүүхэд болон мэндэлсэн. Тэрбээр ах дүү есүүлээ өссөн. Аав нь 16 насандаа Ар хорчин нутгаасаа гарч үзэмчин нутагт суурьшин ажил хөдөлмөр эрхлэн айл гэр болж үр хүүхдүүдээ хоёргүй сэтгэлээр өсгөлцсөн сайн аав. Ээж нь “Үзэмчний Долоо багийн Долоон Отгон”-ы дотор сайхан дуулдгаараа алдартай дуучин хүн байжээ. Ээжийнхээ тухайд Д. Цэрэнванжил “Орой үдэш бидэнд дуу дуулж өгнө. Дууны үг нь онцын содон ухааны утгатайгаар надад цээжлэгдэж байсан болохоор хүний сэтгэлийн уярал хайрын өнгө аясыг уянгын бадгаар илэрхийлэх гэсэн санаа тэр цагаас л миний оюун тархийг нөлөөлсөн байхаа” гэж дурсан бичжээ. Энэ нь ч хожмын түүний яруу найрагт нь өвөрмөц өнгө төрх, аяс хэмнэлийг өгсөн гэж болно. Мөн Шилийнгол аймаг нүүдэлчин соёлын уламжлал, шашны болон хуучны ном туурвилын өв уламжлалтай байдаг нь түүнийн зохиол бүтээлд нөлөөлсөн нь мэдээж.

1970 оны 9 сард гацааны “5, 7” улаан багачуулын бага сургуулиас эрдмийн гараагаа эхлүүлж, тухайн үеийн сор бүтээлүүд болох Д. Нацагдорж, Д. Сэнгээгийн бүтээлээс гадна «Шүй хүүгийн үлгэр», «Гурван улсын үлгэр», «Тал нутгийн хилэнгийн гал», «Бяцхан баатар Юй Лай», «Гялалзсан улаан од» зэрэг ном зохиолыг ихэд шимтэн дурлаж уншдаг байжээ.

1985 онд Өвөр Монголын их сургуулийн монгол хэл утга зохиолын салбарт мэргэжил эзэмшиж, Шилийн хотод Мал аж ахуй машинчлалтын сургуульд монгол хэл бичгийн багшаар ажиллаж байгаад, дараа нь Шилийнгол аймгийн Ажил мэргэжлийн дээд сургуульд багшилсан. 35 жилийн турш багшлахын зэрэгцээ шүлэг зохиол бичиж чамгүй амжилтад хүрчээ. 1987 онд залуухан багш байхдаа «Дөрөөн дээр өндийсөн дэлхий» найраглалаа бичиж, Өвөр Монголын уран зохиолын хамгийн дээд шагнал болох “Солонго”-ын эзэн болов. Энэ үеэс Д. Цэрэнванжил яруу найрагчид олон залуус хадаг барин шавь орж, тэдний дундаас олон зохиолчид төрсөн гарсан юм. Тухайлбал Б. Тогтомж, Б.Мөнхдалай, Баярт, Оргилбулаг, Боргил, Хүмүүжилт, Б. Очирваань нар юм. Эдгээр зохиолчид бүгд Д.Цэрэнванжил багшаас заавар зөвлөмж авч, шүлэг зохиолын өө сэвээ засуулж явсан гэж сайшаан ярьж дурсах дуртай байдаг.

Жишээлбэл, Д. Цэрэнванжилын олон шавийн нэг Б. Тогтомж нь Баруун Сөнид хошууны зохиолчдын эвлэлийн дарга, ӨМӨЗО-ны утга зохиолын дээд шагнал «Солонго»-ын эзэн, Монголын зохиолчдын хорооны «Утга зохиолын төлөө» шагналт том яруу найрагч болж өсөн дэвжжээ. «Монголын гайхамшигтай

¹Шилийн гол (кирилл монголоор Шилийнгол гэж бичвэл илүү зохино; худам монголоор – sili-yin yōul, шили-ийн гоул; хятадаар 錫林郭勒 – xīlínɡuōlè) — БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орон (ӨМӨЗО)-ны аймаг. Нийт 202,580 км² газар нутагтай, төв нь Шилийн хот. Тус аймгийн эдийн засаг нь уул уурхай, хөдөө аж ахуйд тулгуурлана. Шилийнгол аймаг нь хойд талаараа Монгол улс, зүүн талаараа ӨМӨЗО-ны Улаанхад, Түнляо, Хянган, баруун талаараа Улаанцав, өмнө талаараа Хэбэй мужтай хиллэнэ.

яруу найрагч, багшаасаа сурч болох бүх зүйлийг нь сурахсан» гэж Б.Тогтомжийн ярьснаас илэрхий.

БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө засах орны хэмжээнд монгол хэл дээр уран бүтээлээ туурилдаг найрагчдын дунд XX зууны 90-ээд оноос яруу найргийн наадмууд олноороо зохион байгуулагддаг болсон энэ цаг үед яруу найрагч Д. Цэрэнванжил нь “Шүлгийн өрсөлдөөн гэж үгүй, хүн бүр өөрийн онцлогтой” гэж үздэг тул, төдийлөн оролцоод байдаггүй байв. Гэсэн хэдий ч «Гангын урсгал», «Мөнх тэнгэр», «Гилгүүн уянга» наадмуудад оролцож өөрийнхөө ур чадвар хүчээ сорьж байсан байдаг.

Д. Цэрэнванжил нь «Гилгүүн уянга-2006»-д «Он зуун» шүлгээрээ гутгаар байр, дараа жил нь «Яруу найраг буюу өвгөн Донров», «Он зуун», «Мориор эхэлдэг тал», «Гаднаа морьтой монгол айл» шүлгүүдээ уншиж «Мөнх тэнгэр-2007» наадмын цомын эзэн болсон, «Амьдын зам», «Хадан зураг», «Алтан хөвөөтэй цэнхэр далай» шүлгээрээ “Мөнх тэнгэр-2017” наадамд дэд байр, “Гангын урсгал-2017”-д «Алтан хөвөөтэй цэнхэр далай» шүлгээрээ тэргүүн байр тус тус хүртсэн юм.

Өвөр Монголд яруу найргийн олон наадам зохион байгуулагддаг ч хэр хэмжээгээрээ томоохон нь «Мөнх тэнгэр», «Гилгүүн уянга», «Тэнгэрийн ботго», «Өнөр цэцэг», «Торгон Цахар» зэрэг юм. Эдгээрээс хамгийн том нь «Мөнх тэнгэр» наадам болно. Учир нь БНХАУ-ын Монгол утга зохиолын шинжилгээний нийгэмлэгээс санаачлан зохион байгуулдаг Хятадын орны найман муж¹ орноос монгол хэлээр яруу найраг бичдэг ахмад үеийн нэрт найрагчдаас эхлээд идэр залуу үеийнхэн эн тэнцүү өрсөлддөг. Мөн бусад наадмуудаас ялгаатай нь наадамд оролцогч нийт яруу найрагчдыг урьдчилан дөрвөн хэсэг хуваан, хэсэг бүрээс 16, 16 найрагчдыг шалгаруулж, 64 найрагчийг үлдээж, түүнээс 32-ыг шигжиж, эцэст нь 16 найрагчийн бүтээлийг шалгаруулан 1-ээс 16 дугаар байранд шалгаруулдаг онцлогтой.

Мөн тэрээр Өвөр Монголын засгийн ордноос гардуулдаг Өвөр Монголын утга зохиолын дээд шагнал болох «Солонго» шагналыг «Дөрөөн дээр өндийсөн дэлхий» найраглалаараа 1987 онд хорин зургаан насандаа, 2008 онд тавин гурван насандаа «Нууц товчооноос тасарсан адуу» найраглалаараа тус тус хүртсэн.

«Солонго» нэрэмжит уран зохилын шагналыг Өвөр монголын засгийн ордноос санаачлан Өвөр монголын утга зохиолын дээд шагнал болгон 1984 оноос эхлэн зохиолчдод гардуулж эхэлсэн. Тус шагналыг гурван жилд нэг удаа олгож, бүх зардлыг өвөр монголын засгийн ордноос хариуцдаг. Өнөөг хүртэл нийт 12 удаа олгосон байна.

Тухайлбал Өвөр монголын зохиолчдын хорооны тэргүүлэгч асан Аянга, Өвөр Монголын зохиолчдын хорооны дэд тэргүүлэгч байсан алдарт яруу найрагч Артай, “Өнөр цэцэг” сэтгүүлийн ерөнхий найруулагч Лигдэн нар тус шагналыг хоёроос гурав удаа хүртсэн.

Тус шагналыг Д. Цэрэнванжил хоёр удаа хүртэхдээ өдий төдий жилийн алслалтай хүртснээс харахад түүний авьяас билгийн цогц дөх 18 жилд унтраагүйн илрэл бөгөөд дөрвөн удаа томоохон наадамд айрагдаж түрүүлсэн нь түүнийг өнөө цагийн Өвөр монголын яруу найргийн томоохон төлөөлөгч гэдгийг илэрхийлж буй юм.

¹Хятадын найман муж орон гэдэг нь ӨМӨЗО-ноос гадна Хөх нуур, Шиньжян, Ляонин, Гиринь, Ганьсү, Хар мөрөн, Хэбэй мужид аж төрдөг монголчуудыг найман муж орны гэж хэлдэг байна.

2006 онд Монгол Улсад болсон 26 дугаар удаагийн “Дэлхийн яруу найрагчдын” хуралд уригдан оролцсон. Тус хурлын үеэр Монголын засгийн газраас Ноён хутагт Данзанравжаа жанч халсаны 150 жилийн ойд зориулан “Алтан дигваранз” шүлгийн наадмыг зохион байгуулсан. Энэхүү наадамд Д.Цэрэнванжил оролцон “Тусгай” байрын шагнал хүртсэн.

Д. Цэрэнванжилын зохиол бүтээлээ туурвисан гуч гаруй жилийн бүтээлүүдийг шинжлэхээс өмнө түүний уран бүтээлийн аргыг тодорхойлох нь зүйн хэрэг юм. “Уран бүтээлийн арга нь ямар нэгэн хийсвэр зүйл биш бөгөөд тодорхой түүхэн нөхцөл, уран бүтээлийн явц дунд бий болдог, амьдралыг уран сайхнаар танин мэдэх явцад төгөлдөрждөг зүйл” (Байгалсайхан, 1995: 112) юмаа. Иймд түүний төрсөн, өссөн, оршин буй нийгмийн тухай өгүүлэх нь зайлшгүй.

БНХАУ 1954, 1975, 1978, 1982 онд үндсэн хуулиа шинэчилжээ. Эдгээр үндсэн хуулиудаар Хятад улсын дотор байх цөөн тоот үндэстнүүдийн асуудал л давхар орж явсан. Мөн дээр өгүүлсэн Соёлын хувьсгалын он жилүүд дуусаж 1979 оноос Хятад улсын нийгмийн хөгжлийн түүхэн дэх тодорхой онцлогтой үе ирсэн гэж хэлж болно. Үүний нэг жишээ нь: соёлын нэг ухагдахуун болох БНХАУ эхэндээ шашныг хориглосон ч 1980-аад оноос хяналттай чөлөөлжээ.

Нийгэмд гарсан эдгээр өөрчлөлтийн үр дүнд нь өмнөх үеэсээ илүү их эрх чөлөөтэй сэтгэх цаг үе ирж, Д. Цэрэнванжилын уран бүтээлийн эхэн үе үүнтэй таарч, монгол яруу найргийн уламжлал шинэчлэлийг хамтатган зохиол бүтээлээ туурвих болсон юм. Мөн дээр өгүүлсэнчлэн их гүрний дотор орших жижиг үндэстний үзэл түүний зохиол бүтээлд нэвт шингэсэн (Цоморлиг, 2022).

Үүний нэг баталгаа нь түүний «Нүүдэлчний намар», «Мөнхийн зоог» зэрэг найруулал нь дунд сургуулийн хичээлийн “Сурах бичигт” орж, БНХАУ д монгол дунд сургуулийн мянга мянган сурагчдын хүртээл болжээ. Энэхүү хоёр найруулал 2004 онд сурах бичигт орж хэвлэгдсэнээс нааш ойролцоогоор нэг сая орчим сурагчдад хүрсэн дүн мэдээг үндэслэвэл, түүнийг монгол өвийг өвлүүлэгч, Өвөр Монголын яруу найргийн нэрт төлөөлөгч болохыг баталж болох юм.

Тэрбээр өдгөө БНХАУ-ын цөөн тоот үндэстний зохиолчдын нийгэмлэгийн гишүүн, Өвөр Монголын зохиолчдын нийгэмлэгийн гишүүн, Шилийнгол аймгийн зохиолчдын нийгэмлэгийн дэд тэргүүлэгч зэрэг олон нийтийн байгууллагад алба хашиж явна.

2. Д. Цэрэнванжилын шүлэг зохиолын өвөрмөц тал

Эх Отгон нь нутаг усандаа хүндлэгдсэн дуучин хүн байсан. Орой үдэш ардын дуу дуулдаг байсан нь түүний уран бүтээлд түлхэц болсон. Хүүхэд ахуй насандаа бага сага мөр холбож бичиж эхэлсэн ба 1982 онд 21 настайдаа анхны «Нутгийн салхи» шүлгээ Өвөр Монголын их сургуулийн сонинд нийтлүүлсэн.

Түүнээс хойш «Талын цэнхэр найраг», «Эр хүн сайхан», «Үүр тийшээ салхилсан цэцгийн тал», «Уянгын нэг чулууг дамнаж хоносон шөнө», «Гаднаа морьтой монгол айл» зэрэг зуу гаруй шүлгийг нийтлүүлж олны хүртээл болгосон юм. Бүтээлийн дийлэнх нь сургамжит шүлэг /басня/ байна. Шүлэглэх арга техникийн хувьд толгой сүүл холбох уламжлалт аргатай, яруу найргийн уран илэрхийллийн хэрэглээр болох дүрслэх, адилтгах, зүйрлэх, утга шилжүүлэх, чимэг үг зэрэг аргуудыг түгээмэл ашигладаг. Сургамжит шүлэг /басня/ хэмжээгээр тийм том биш, ихэвчлэн сургаалын чанартай өгүүлэмж бүхий шүлэглэлт зохиол юм (Байгалсайхан, 1995: 67).

Сургамжит шүлэг бичигчид нь ихэвчлэн ан амьтнаар төлөөлүүлэн, тэдний төрөлхийн зан чанараар нь ямар нэгэн шинж чанарыг тодотгон үзүүлдэг байна. Утга зохиолын онол судлалын ихэнх ном бүтээлд сургамжит шүлгийг уянга-туульсын төрөлд хамааруулан авч үздэг. Түүний дүрслэгдэхүүн өгүүлэх хэлбэр зэрэг нь өгүүллэг, туурь, явган яриа зэрэгтэй их ойр дөт болгодог (Байгалсайхан, 1995: 67). Түүний нийтэд хүртээл болж хэвлэгдсэн бүтээлүүдэд “таван хошуу мал”, “нүүдэл”, “нутаг”, “чулуу” зэрэг үг, агуулга, сэдэв олон байдаг.

Д. Цэрэнванжилын нийтлэгдсэн бүтээлүүдэд чулуу гэсэн үг орсон 33 зохиол байна. Тэрээр чулууны бодит чанарын тухай болон чулуугаар төсөөлүүлж, мөн чулуутай харьцуулан бичсэн байна. “Шинжлэх ухаан бол онолын дүгнэлт томъёоллоор сэтгэн юмс үзэгдлийн аливаа шинж чанарыг нэгийг нөгөөгөөр батлах, харьцуулан батлах аргаар танин мэдэх үйл явуулдаг бол уран зохиол дүрээр сэтгэн урнаар дүрслэн үзүүлэх аргаар танин мэдэх үйлээ явуулдаг” (Байгалсайхан, 1995: 7) чулууг Олон Улсын Хөрс Судлалын Нийгэмлэгээс “2 мм ээс дээш голчтой хатуу эрдэс юм” гэж тодорхойлсон ч яруу найрагт чулууны шинж чанарыг ашиглан бичих нь олонтой.

Жишээ нь, Д.Нацагдоржийн нэрэмжит шагналт Данзангийн Нямаагийн «Чулуун уй» шүлэгт:

Чухамдаа минийхээс илүү, дутуу нь ямар бол доо.

Чулуунд мэдээж уй гуниг байдаг л байх даа.

Ямартаа л хээр талд сэвтэж, цавтталаа,

Амартаа л ямар хэвтэж байв л гэж үү дээ.

Хөлтэй бол явахсан гэж,

Хэлтэй бол ярихсан гэж,

Дуулдаг ч билүү,

Үйлдэг ч билүү,

Яаж мэдлээ дээ

хэмээн шүлэглэсэн нь чулууг амьдчилж бичсэн нь бий.

Тэгвэл Д. Цэрэнванжил «Энэ гаригийн нар» шүлэгтээ:

Энэ гаригтай

Сэтгэлд хүндхэн чулуу байгаа

Эцэг хүний

Ширүүн бор нүдтэй

Уулын чулуу зүүдэлж,

Эчнээх аяны

Даанч холоо санаж,

Энэ гарагийн наран

Эргэж ургадаг юм байна

хэмээн “сэтгэлд хүндхэн чулуу байгаа” гэж чулууны хүнд физик чанарыг сэтгэл хүнд гэдгийг зүйрлэсэн байна.

Мөн Ачит эцэг, эх орныхоо дурсгалд

Чулуу бүхнийг энэрэн

Чулуу бүхнийг хорсон

Тэнгэрээс ондоо эзэнгүй

Энэ говийн улс

хэмээн чулууг эх газар, эх дэлхий хэмээх үгтэй утга шилжүүлэн бичсэн (Шар мөрөн сэтгүүл, 1989 он, дугаар 4).

Мөн түүний өргөн ашигладаг сэдэв «Морь» түүний нийтлэгдсэн 23 шүлгэнд тухайн үг орсон. Морь бол зөвхөн монгол хэл дээрх уран зохиолд төдийгүй аман ардын зохиолд, тухайлбал тууль, дуунуудт (Омакаева, 2019; Бадмаева, 2023), зүйр цэцэн үгсэд (Омакаева, Боваева, 2019; Омакаева, Таганова, Куллыева, 2019 гэх мэт) дуртай дүр гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

Мөн бүтээлүүдийг судлах явцад төгсгөлийн өгүүлбэр буюу цогцолборын нэг утганд “Морь” гэсэн утгатай дүйх үг орсон долоон бүтээл байна. Жишээлбэл: «Мориор эхэлдэг тал шүлэг»:

Салхин хурдан гүйдэлтэй,

Санасан сайхан заяатай,

Саран нарны бэлчээртэй,

Сайрам бүрд нутагтай

Сансрын хурдан хүлэг.

Монголын молор эрдэнэ

Энэ хүлэг

Адуу үнэхээр

Байсан ч байж магадгүй.

«Морины хөлс» шүлэгт:

Нарны тоогоор өдрөө нэмж,

Мэндийн сайхныг

Нэгэндээ жиргээж шувуу ниснэм

Нэг нас нэмэгдсэнээ

Аав ээжээрээ ерөөлгөж,

Цагаан сарын өлзийд би

Морьтойгоо жаргаж хононом.

«Өвгөн буурал нутаг» шүлэгт:

Догшин хүрэн бүргэд чинь

Өдөө засаж уйлахыг

Хараад, би

Морио эмээллэлээ.

«Өнө мөнхийн морьд» шүлэгт:

Өнө мөнх морьдын туурай бол янаг хүүхний уруул

Эсвэл амь үхлийн харанхуй үер

Сэтгэлийн үхэшгүй эцэг хүмүүс

зэргээр шүлгийн утгаа задлаж буй сүүлийн өгүүлбэрт оруулсан байна.

Энэ мэт өдий төдий олон шүлгээрээ монгол ахуй амьдрал, нүүдэлчин сэтгэлгээг өөрийн үгсийн сан, судалсан судалгааны баялагаа олон эгэл ардад шүлгээр дамжуулан соёлыг уламжлаж буй уран бүтээлч юм. Энэ нь ч түүний БНХАУ-ын монгол яруу найрагчдын дунд зохиогддог «Гилгүүн уянга» наадмаас дэд байр хүртсэн «Он зуун» шүлэгт тодорхой харагддаг.

«Он зуун» гэсэн богино шүлгийг найрагч «Шилийнгол» сэтгүүлийн 2006 оны 5-р дугаарт нийтлэн олны хүртээл болгосон.

Он зуун

Үгэнд юүлбэл,

Ургааж бардаггүй “Тэнгэрийн салхи”

Намайг дуулж гүйцээнэ.

Үлгэрт юүлбэл,
Уйлж суусан арван гурван өндөгтэй
Алаг шаазгай
Намайг хуурч гүйцээнэ.
Орчлонд юүлбэл,
Од нь тосорхож хөвсөн
Нүүдлийн эхүүн хар цай
Намайг залгилж гүйцээнэ.
Биедээ юүлбэл,
Баярлаж завдахгүй зуун намрын
Гоморхол
Намайг нүцгэн гүйцээнэ.
Тоонд юүлбэл,
Таван хурууны өндгөнд багтаж,
Мэлмэрсэн
Мөрөөдлийн нулимс
Намайг хүлээлгэж гүйцээнэ.
Тоосонд юүлбэл,
Наран сарны чимээнд ургасан
Дөрвөн цагийн жиргээ
Намайг тэлж гүйцээнэ.
Монголдоо юүлбэл,
Морин хуурын утсан дээр буйлсан
Өнчин цагаан ботго
Би Монголоороо гүйцээнэ.
Гүйцээнэ гэдэгт юүлбэл,
Мөнгөн туйлиасаа авчихсан
Нүдэн цэнхэр бөмбөлөг
Би харж гүйцээнэ.
Гүйцнэ гэдэгт юүлбэл,
Эхэн төгсгөл хоёроо
Ээлжээр ирч гишгэсэн
Амьтны мөр
Би дунд нь гүйцнэ («Шилийн гол» сэтгүүл, 2006 он, дугаар 12).

Энэ шүлэг нь хязгааргүйн нэрийдэл, ингэхэд найрагчаас зарим хязгаартай «Хорвоогийн жам» өгөгдөлд оногдуулан он зууны өнгө төрх, аялуу, утгыг домоглог монгол ухаарлаар тодорхойлсон. Жишээлбэл:

Үгэнд юүлбэл,
Ургаж бардаггүй “Тэнгэрийн салхи”
Намайг дуулж гүйцээнэ.
Үлгэрт юүлбэл,
Уйлж суусан арван гурван өндөгтэй
Алаг шаазгай
Намайг хуурч гүйцээнэ

гэсэн мөрүүдэд “Тэнгэрийн салхи”-ийг дуугаар төсөөлүүлэн, үгээр дууг бүтээж би тэр дууг дуулсаар байгаад үгүйрнэ гэсэн санааг агуулсан мэт сэтгэгдэл төрүүлнэ.

Ер нь *тэнгэр* бол монголчуудын эртний шүтээн: “Төв Азийн нүүдэлчид эрт дээр үеэс тэнгэр ба газрыг шүтэж ирсэн бөгөөд нүүдэлчдийн хувьд тэнгэр нь бусад ард түмнүүдийн бурхны адил үүрэг гүйцэтгэж байв” (Бира, 2006: 34) гэснээс үзвэл, тэнгэр бол шүтээн, тэнгэрийн салхи бол шүтээний өгүүлэмж буюу дуу хоолой мөн. Монгол ардын үлгэр бол хүмүүний амьдралын жам ёсыг уран сайхны аргаар өгүүлдэг урлаг. Араат улаан үнэгэнд хууртаж, өндгөө идүүлчихээд, уйлж суугаа үлгэрийн алаг шаазгайтай биеэ зүйрлэсэн. Энэ шүлгийн бүхэллэг санаа нь орчлонгийн эргэж хөвөрсөн амьдралын тухай тэнд нь хүмүүн бид багтаж, заримдаа дагаж, заримдаа сөрж тэмцдэг гэсэн утга юм. Шүлгийн нэг санаа буюу бадгийн төгсгөлд байх “гүйцээнэ” гэсэн нь туулна гэсэн үгтэй дүйх ба “гүйцнэ” гэдэг нь бид хувь заяаныхаа эзэн нь гэсэн утга агуулж байна.

Мөн Д. Цэрэнванжилд “нутаг” усны тухай олон шүлэг бий. Монгол хэлний тайлбар тольд “Төрж өссөн, оршин суух газар орон: төрөлх нутаг (төрж өссөн нутаг)”¹ гэсэн. Ер нь яруу найрагч, уран бүтээлчээс эхлээд энгийн ард гээд бүх л хүмүүс өөрийн унасан газар, угаасан усыг магтан дуулдаг. Жишээлбэл, орчин үеийн утга зохиолыг үндэслэгч, их зохиолч Д.Нацагдоржийн “Монгол улсын томоохон уул нуруу, гол мөрөн, говь хангайг тоочин: Энэ бол миний төрсөн нутаг Монголын сайхан орон” гэж бичсэн «Миний нутаг» шүлгээс эхлээд Б.Лхагвасүрэнгийн «Боржгоны бор тал», П.Бадарчийн «Есөн эрдэнийн орон», Ч.Чимэдийн «Би монгол хүн», Б.Явуухулангийн «Би хаана төрөө вэ?» зэрэг маш олон зохиол бүтээлийг дурдаж болохоор байна.

Энэ нь ч улс үндэсний үндэстний ухамсарын дархлааг бий болгодог байж ч мэднэ. Тухайлбал Дундад улсын Монгол утга зохиол шинжилгээний нийгэмлэгийн нарийн бичгийн дарга, Өвөр Монголын Их Сургуулийн доктор, професор С. Урсгал «Монгол шүлэг зүй ба утга зохиолын түүх зүй судлал» номондоо “Яруу найрагт өөр би-гийн бухимдал гутрал, харамсал, гэмшил, горьдол хийрхлийг уянгалж болохоор барахгүй ямар нэгэн үед хүний ур чадавхийн хүсэл шунал, хурьцал, тачаал зэргийг ч илрүүлж байсан билээ. Гэвч тэдгээр нь цаг урсгалын түлхэлт таталтад сонгогдон шилэгдсээр өөрийнхөө үнэ цэнийг харуулдаг жамтай. Нийгэм түүхийн онцгой хувьслаас хүн ахуйн оршил тогтнолд цаашлаад үндэстэн, ястны соёлын системд хямрал сүйдлийн дохио тэмдэг ч элэрч мэднэ” (Урсгал, 2010: 9) хэмээн тусгасан байна. Тодруулбал, яруу найрагч гэдэг нь цаг үеийн байдлыг урьдаас мэдэрч, зохиол бүтээлээрээ эгэл ардад таниулан ойлгуулдаг. Өвөр Монголын одоо үеийн уран зохиолын нийтлэг байдал нь мөн ч өнөө үеийн нийгмийн байдалтай нягт холбоотой нь мэдээж. Д. Цэрэнванжил ч мөн өнөөгийн Өвөр Монголын нүүдэлчин ахуйгаасаа холдон хотжиж буйг ихэд шүүмжлэн, өнөө болон ирээдүй хойчисдоо монгол ахуйг сурталчилдаг. Энэ ч утгаараа түүний нийтлэгдсэн зохиол бүтээлд “нутаг” гэсэн үг орсон 22 бүтээл байна. Жишээлбэл, «Алтан шагай мөнгөн шагай» /Шүлэг/:

Малаа мянган түм өсгөсөн

Малчин ардынхаа гарт

Ай, хүү минь,

Аав нь мартчихжээ.

Алтан шагай

Мөнгөн шагай хоёрыг чинь

Нутаг дээрээ мартчихжээ.

¹<https://mongoltoli.mn/search.php?opt=1&word=%D0%BD%D1%83%D1%82%D0%B0%D0%B3#>

Цагийн эрх хойно
Яахав ээ, хүү минь,
Тас шувууны зулзага
Өдлөхөөсөө эхэлж нисээд,
Өтлөөд,
Эцсийн өд нь унахаар
Нүдний үзүүрт цэнхэртэх
Уулсын бэл дагуу
Ай түмэн адуу
Бэлчиж байдаг нь харагдана.
Салхины үзүүр дагаж,
Сайрам бүрдийн ус
Шалдан хүүхэд шиг
Жирвэгнэж байдаг нь харагдана гэнэ.
Ангир өргөөний хотонд
Амгайгаа хүлхсэн
Догшин морьд
Зэлээ тойрч
Үүрсэж байдаг нь сонсдоно гэнэ.
Ай
Тэр нутаг гэж...
Малчин монгол улс
Дөрвөн цагийнхаа
Хөл дээр жиргэнэ.
Мянга түмэн малтай
Мандсан гүрний эзэд
Алтан шагай,
Мөнгөн шагайг
Хоёр гараараа сэлгэн
Сага авч,
Мандалт тэнгэрийн
Дээвэр доорын
Найрлалдан суужээ.
Ай,
Тэр нутаг гэж ...

“Шинжлэх ухаан болон онолын дүгнэлт томъёололоор сэтгэн юмс үзэгдлийн аливаа шинж чанарыг нэгийг нөгөөгөөр батлах, харьцуулан батлах аргаар танин мэдэх үйлээ явуулдаг бол, уран зохиол дүрээр сэтгэн урнаар дүрслэн үзүүлэх аргаар танин мэдэх үйлээ явуулдаг” гэснийг баримталбал, уг шүлгээс

Тас шувууны зулзага
Өдлөхөөсөө эхэлж нисээд,
Өтлөөд,
Эцсийн өд нь унахаар
Нүдний үзүүрт цэнхэртэх

Уулсын бэл дагуу

Ай түмэн адуу

Бэлчиж байдаг нь харагдана

гэдгийг уншихад, тас шувууны амьдралыг нүдэнд харагдахуйц дүрсэлж буйгаар батлагдаж байна.

Дээр өгүүлсэнчлэн, түүний шүлгийн олонх нь сургамжит шүлгийн гэсэн хэдий ч зохиолчийн “уран бүтээлийн арга нь заавал нэг хүнд үргэлж байх ёстой зүйл ч бас биш юм” (Байгалсайхан, 1995: 113). Харин түүний уран бүтээлийн агуулга нь их төлөв соёл уруу чиглэсэн байна. Соёл гэдэг нь “Нийгмийн хөгжлийн явцад хүн төрөлхтний бүтээсэн эд баялаг, оюун ухааны ололтын цогц” (Баярсайхан, 2009: 552) юм. Түүний бүтээлд нүүдэлчин соёлын сайхныг магтан, соёлыг нь бүтээсэн хүн зон, байгаль дэлхийн гайхамшгийг өгүүлдэгээрээ онцлогтой.

Д. Цэрэнванжилын уран бүтээлийн агуулга сэдэв өргөн дэлгэр, орчин үеийн түүхэн амьдралаас одоо үеийн хот хөдөөгийн амьдралыг хамарсан байна. Тэр бээр малчин айлд төрж өссөн болохоор тухайн үеийн хөдөөгийн байдлыг нарийн нягт ойлгон таньсан тул уран бүтээлийнх гол сэдэв чиглэл болсон. Хөдөө нутгийн малчин айлын аж амьдралаар дэвсгэр болгон монголчуудын нүүдлийн ахуй байдал, монголчуудын хувь заяаны талаарх өөрийн гэсэн үзэл бодлоо илэрхийлж байдаг. «Дөрөөн дээр өндийсөн дэлхий»-н яруу найргийн хүлгийн хиймориор “Солонго”-гийн хишиг хүртэж, «Дорно дахины өчил» найраглалаар домогзүйн урамсын галыг хөгжөөн дүрэлзүүлэн давхиж «Нууц товчооноос тасарсан адуу»-гаа хураахаар холын эрэлд мордсон нь түүний уран бүтээлийн гол онцлог болох юм.

Д. Цэрэнванжилын яруу найргийн хэл найруулга, дүр дүрслэлд “таван хошуу мал”, “нүүдэл”, “чулуу”, “морь”, “түүх” гэх мэт үгсийг байнга давтан хэрэглэх нь олонтоо тохиолдож байна. Эдгээр үгсээр дамжуулан тэрбээр монгол үндэстний сэтгэлгээгээ илэрхийлсэн олон шүлэг найргийг зохиожээ.

Мөн тэрээр Өвөр Монголын засгийн ордноос гардуулдаг Өвөр Монголын утга зохиолын дээд шагнал «Солонго» шагналыг «Дөрөөн дээр өндийсөн дэлхий» найраглалаараа 1987 онд хорин зургаан насандаа анх удаа, 2008 онд дөчин долоон насандаа «Нууц товчооноос тасарсан адуу» найраглалаараа хоёр дахь удаагаа тус тус хүртсэн юм.

ДҮГНЭЛТ

Өнөөдөр ч Д. Цэрэнванжил монгол соёлын өв уламжлал, нүүдэлчин түмний сэтгэхүйн өвөрмөц онцлогийг уран бүтээлээрээ уламжлан авч явсаар байгаа билээ. Үүний нэг баталгаа нь түүний «Нүүдэлчний намар», гэх нүүдлийн ахуйг санагалзсан уянгат аястай найруулал, «Мөнхийн зоог» гэх монголын домог-үлгэрийн уламжлалаас сэдэвлэсэн “нар — хоньчин хүү, хоньчин хүү — нар, нар — өндөр настан хоньчин, өндөр настан хоньчин — нар хүү” харилцан яриан дахь малд нүдтэй сайн малчин болох харилцан яриагаар монгол хүн, байгаль дэлхийтэй хүйн холбоотой тухайд өгүүлсэн эргэцүүлэлт найраглал нь дунд сургуулийн хичээлийн “Сурах бичигт” орж, БНХАУ-д Монгол хэлээр хичээллэж буй монгол дунд сургуулийн мянга мянган сурагчдын хүртээл болон, монгол соёлын үрийг тарьж буй явдал юм.

Энэхүү хоёр бүтээлийг багтаасан сурах бичиг 2004 онд хэвлэгдсэн ба ойролцоогоор нэг сая орчим сурагчдад хүрсэн дүн мэдээг үндэслэвэл тэр бээр монгол өвийг өсвөр насныханд өвлүүлэгч, Өвөр Монголын яруу найргийн нэрт төлөөлөгч болох нь харагдаж байна.

Ном зүй

Бадмаева, Е.Н. (2023). Культ коня в эпосе «Джангар» и национальное самосознание кочевого калмыцкого народа в условиях природно-климатических факторов. *International Symposium on the Exchange and Blending of Silk Road and Multi-ethnic Languages and Literature*. Ланьчжоу: Северо-Западный университет национальностей. 170–175.

Байгалсайхан, С. (1995). *Уран зохиол шинжлэлийн удиртгал*. Улаанбаатар.

Баярсайхан, Б. (2009). *Монгол хэлний хураангуй тайлбар толь*. Улаанбаатар: Монсудар хэвлэлийн газар.

Бира, Ш. (2006). *Их Монгол улсын түүх, үзэл суртлын зарим онцлог асуудлууд*. Улаанбаатар.

Омакаева, Э. У. (2019). Образ коня в эпическом и песенном творчестве калмыков и ойратов: номинации масти (на материале опубликованных, архивных и полевых источников). *Монголы: традиции и современность*. Чтения памяти Е.С. Новик. Материалы международной научной конференции. Москва, РГГУ, 11–13 сентября 2019 г. / *Mongols: Traditions and Modernity. III Readings in the Memory of Elena S. Novik. Abstracts*. Moscow, RSUH, September 11–13, 2019. Сост. и ред. А.А. Соловьева, О.Б. Христофорова / Eds. A. Solovyova, O. Khristoforova. Москва. 27–29.

Омакаева, Э. У., Боваева, Г.М. и др. (2019). Зооморфный код культуры в зеркале калмыцких и монгольских пословиц: зоолексема мөрн ‘конь’. *Социальные и культурные трансформации в контексте современного глобализма*. Сборник научных трудов. 3. Грозный: СибИздатСервис. 690–694.

Омакаева, Э.У., Таганова, М.А., Куллыева, М. (2019). Зоолексема мөрн/морь/ат ‘конь’ в калмыцких, монгольских и туркменских пословицах на фоне русских: лексико-семантическая и словообразовательная характеристика. *Алтайское языкознание: проблемы и исследования*. Горно-Алтайск.

Урсгал, С. (2010). *Монгол шүлэг зүй ба утга зохиолын түүх зүй судлал*. Хөх хот.

Цоморлиг, С. (2022). Өвөр Монголын яруу найрагч Д. Цэрэнванжилын найраглал, найрууллын үндэсний соёлын ач холбогдол. *Nomadic civilization: historical research*. 2(4). 65–79.

References

Badmaeva, E.N. (2023). The cult horse in the epic “Dzhangar” and the national self-consciousness of the nomadic Kalmyk people under the conditions of natural and climatic factors. *International Symposium on the Exchange and Blending of Silk Road and Multi-ethnic Languages and Literature*. Lanzhou: Northwestern University of Nationalities. 170–175.

Baigalsaikhan, S. (1995). *An Introduction to Literary Analysis*. Ulaanbaatar.

Bayarsaikhan, B. (2009). *A concise dictionary of the Mongolian language*. Ulaanbaatar: Monsudar Publishing House.

Bira, Sh. (2006). *Some special problems of the history and ideology of Great Mongolia*. Ulaanbaatar.

Omaekava, E. U. (2019). The image of a horse in the epic and song texts of Kalmyks and Oirats: nominations of coat colours (on material of published, archival and field sources). *Mongolian: tradition*

and modernity. Materials of International Science Conference. Moscow: Russian State University, September 11–13, 2019. Eds. A. Solovyova, O. Khristoforova. Moscow. 27–29.

Omakaeva, E. U., Bovaeva, G.M., etc. (2019). Zoomorphic code of culture in the mirror of Kalmyk and Mongol proverbs: zoolexeme ‘horse’. *Social and cultural transformations in the context of modern globalism*. Collection of scientific works. 3. Grozny: SibIzdatService. 690–694.

Omakaeva, E.U., Taganova, M.A., Kullyeva, M. (2019). Zoolexeme мqrн/морь/at ‘horse’ in Kalmyk, Mongolian and Turkmen proverbs on Russian background: lexical-semantic and word-formation characteristics. *Altai linguistics: problems and research*. Gorno-Altai.

Ursgal, S. (2010). Mongolian poetry and literary historiography. Hohhot.

Tsomorlig, S. (2022). National-cultural significance of the poetry of Inner Mongolian poet D. Tserenvanjil. *Nomadic civilization: historical research*. 2(4). 65–79.